



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц,  
орон тоо батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 9.1.6, 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банк хоорондын 2017 оны 7 дугаар сарын 5-ны санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу байгуулагдсан “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн болон “Засаглалыг дэмжих төсөл”-ийн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.

2. Төслийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилтийн газар /И.Батхүү/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 6 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

975056

Сангийн сайдын ... тоны ... дугаар сарын ...-  
ны өдрийн ... тоот тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ДЭЛХИЙН БАНК ХАМТРАХ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
"ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ" болон  
"ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ" -ИЙН НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
НЭГЖИЙН БҮТЭЦ, ОРОН ТОО

	Албан тушаалын нэр	орон тоо
	<b>Төсөл хэрэгжүүлэх нэгж</b>	
1	Төслийн зохицуулагч	1
2	Санхүүгийн ажилтан	1
3	Худалдан авалтын ажилтан	2
4	Хяналт, шинжилгээ үнэлгээний ажилтан	1
5	Туслах ажилтан	1
	<b>Нийт</b>	<b>6</b>